



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 83 дугаар тогтоолын хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ДЭРГЭДЭХ
“ХҮҮХДИЙГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” ОРОН
ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ**

1. ЕБС бүр “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” орон тооны бус зөвлөлийг /ХТТ-ийн сургууль хариуцсан арга зүйч, БСГ-ын арга зүйч, сургуулийн захирал, эрхлэгч, нийгмийн ажилтан, хүүхдийн ОНБ-ын төлөөлөл, эцэг эхийн төлөөлөл/ 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулах. Зөвлөлийн дарга нь тухай сургуулийн захирал байна.
2. Зөвлөл нь хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль, эрх зүй, ёс зүйн хүмүүжил олгох, хүүхдийг хэвийн сурч хүмүүжих нөхцөлийг хангах.
3. Хүүхдийн эрхийг хамгаалах, тэднийг гэмт хэрэг, гаж зуршлаас урьдчилан сэргийлэх, эрх зүйн зөрчилд орсон хүүхдүүд, тэдний эцэг эх, асран хамгаалагч нартай уулзалт, өдөрлөг, сургалт, семинар зохион байгуулж хүүхдийн хүмүүжил төлөвшилд нөлөөлөхүйц үйл ажиллагааг тогтмол явуулах.
4. Хүүхдийн сургууль завсардалт, ёс суртахууны доройтол, гэмт хэргийн өсөлт, зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийг бууруулах талаар эцэг эх, сургууль багш нарын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдний үүрэг хариуцлагыг өндөржүүлэхэд анхаарч ажиллах.
5. Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хүүхдийг өөрийн оролцоог нэмэгдүүлж, тэдний үүсгэл санаачлагыг дэмжиж ажиллах.
6. Хүүхдийн эрх ашгийг хохироосон гэм буруутай эцэг эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгч, иргэдийг зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн сануулга өгч шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагад хандах.
7. Орон нутгийн төр захиргаа, хууль хяналт, цагдаа, хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн байгууллагын хүүхдийн асуудлаар хэрэгжүүлж буй үйл

ажмллагаатай ажлаа уялдуулж байнгын хамтын ажиллагаа тогтоох.

8. Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа улирал бүр Цагдаагийн газрын Хүүхдийн албанд ирүүлж байх.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид